

Хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Булган аймгийн Засаг даргын баталсан 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 1/10 дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2019 оны 06 дугаар сарын 17-оос хуанлын 5 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, туслах аж ахуйн тооцоо, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хангал сумын гуравдугаар багт байрлах 9013342 регистрийн дугаартай Хангал сумын ерөнхий боловсролын сургууль нь захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, насан туршийн боловсролын багш, бага ангийн багш 5, дунд ангийн багш 8, номын санч бичиг хэрэг, нярав, дотуур байрны багш, дотуур байрны тогооч, үдийн цайны тогооч, сургуулийн үйлчлэгч 2, дотуур байрны жижүүр 3, слесарь, сахиул /малчин/, галч 4 гэсэн 33 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Шалгагдсан хугацааны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг 2018 оны 01 сарын 01-ээс 2018 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Х.Тамжид, хоёрдугаар гарын үсгийг 2018 оны 01 сарын 01-ээс 04 сарын 30-ныг хүртэл Ж.Балжинням, 2018 оны 05 сарын 01-ээс 10 сарын 31-ний өдөр хүртэл Ч.Даваажаргал, 2018 оны 11 сарын 01-ээс 12 сарын 31-ний өдөр хүртэл Ө.Мөнхжаргал нар зурж, сумын

төрийн санд бүртгэлийн 100041115101 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041115401 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэн хөтөлсөн байна.

Шалгалтанд хамрагдсан хугацаанд няраваар П.Наранцэцэг ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан нь аудитын түүвэрт хамрагдсан ба тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

ЗУРГАА. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Хангал сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоодын хяналт шалгалтыг хийсэн байна.

Дотоодын хяналтаар цалингийн цэс гарын үсэг зуруулаагүй, бэлэн мөнгө хүссэн өргөдөл дугааргүй, түлээний шатахууны зарцуулалтыг нягтлан бодогч тооцдоггүй, байгууллага руу бэлэн бус гүйлгээ хийхдээ нэхэмжлэл аваагүй, зарлагын баримтын үнийн дүнгээр шууд гүйлгээ хийдэг, иргэн Б.Найрамдалтай усны гэрээ хийгээд нотариатаар батлуулаагүй, гэрээ нь эрх зүйн шаардлага хангаагүй, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн ч илтгэх хуудас байхгүй зөрчил илэрсэн.

Харин эд хөрөнгийн картыг бүрэн хөтөлсөн, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан, шалгагдсан хугацаанд өр, авлага үүсгэлгүйгээр батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ололттой талтай

Ил тод мэдээллийн самбарт сарын мэдээ, улирлын санхүүгийн тайланг мэдээлсэн, шилэн дансны нэгдсэн цахим сайтад мэдээллийг санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 1-4 сарын төсвийн гүйцэтгэл, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ гараагүй гэж мэдээлсэн байсанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

ДОЛОО. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад Хангал сумын ерөнхий боловсролын сургууль нь 2018 онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээлэл болох санхүүгийн тайлангийн бүтэн жилээрх мэдээллийг мэдээлээгүй байна.

НАЙМ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны касс, харилцах, аж ахуйн баримт, өмч хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, ажлын цаг ашиглалтын бүртгэл, хүнсний агуулахын бүртгэл, багшийн журнал, дотуур байрны багшийн бүртгэл, тайлан баланс, дотоод хяналт хийсэн шалгалтын материал зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч асан Ч.Даваажаргал, Ж.Балжинням, нярав П.Наранцэцэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

8.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2018 онд улсын төсвөөс 388,481.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, санхүүжилтийг бүрэн авсан, нэмэлт санхүүжилтийн дансаар 3,049.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 678.0 мянган төгрөг оруулахаас 1,510.3 мянган төгрөгийг оруулж нийт 393,041.9 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 832.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Төсөвт зардлыг 389,159.7 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 250,904.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 30,037.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 22,245.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3,195.9 мянган төгрөг, нормативт зардалд 15,018.2 мянган төгрөг, урсгал засварын зардалд 7,868.7 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 118.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 220.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 5,046.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох тэтгэмжид 9,660.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжид 35,686.8 мянган төгрөг, үдий цайны зардалд 6,159.6 мянган төгрөг, төсвийн дотоод эх үүсвэрээр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахад 5,906.3 мянган төгрөг нийт 392,067.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 974.3 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 15,285.6 мянган төгрөгөөр төлөвлөж 5592 хүүхэд өдөрт 13,186.6 мянган төгрөгийн хүнс зарцуулж нэг хүүхдэд өдөрт 2358 төгрөгийн хоол, үдийн цайны зардлыг 6,159.6 мянган төгрөгөөр төлөвлөж 11008 хүүхэд өдөрт 7,213.1 мянган төгрөгийн хүнс зарцуулж нэг хүүхдэд өдөрт дунджаар 655 төгрөгийн хоол, хүнс олгосон байна.

Тус сумын суурь боловсролын сургуулийн багш, ажиллагсад 3 өдрийн цалин болох 1,513.2 мянган төгрөгийг аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд хандивлажээ.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Тайлант онд БСУГазраас тэтгэлэгт хөтөлбөрийн зардал 959.9 мянган төгрөг, нэмэгдэл цалингийн 2,000.0 мянган төгрөг, Байгаль хамгаалах сангаас уралдааны болзолын 90.0 мянган төгрөг, ноолуурын орлого 1447.0 мянган төгрөг, заалны орлого 63.3 мянган төгрөг нийт 4,560.2 мянган төгрөгийн орлого орсон байна.

Байгалийн ухааны кабинетэд 799.9 мянган төгрөгөөр зурагт, 150.0 мянган төгрөгөөр хулдаас, Мини волейболын хүлээн авалтын зардалд 250.0 мянган төгрөг, өвс, хивэг, тэжээл худалдан авахад 117.5 мянган төгрөг, спортын бага наадмын оролцооны мөнгөнд 300.0 мянган төгрөг, шатахуунд 150.0 мянган төгрөг, вакуум хаалгын үнийн зөрүү 629.5 мянган төгрөг, бараа материалын зардалд 163.3 мянган төгрөг, БСШУСЯамнаас нэмэгдэл цалинд 2000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тэтгэмжийн талаар:

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дахь заалтын дагуу байгалийн ухаан, орос хэлний багш Г.Жаргалд 20,077.2 мянган төгрөг, нярав П.Наранцэцэгт 8443.8 мянган төгрөг, галч Г.Эрдэнээд 7165.8 мянган төгрөг бүгд 35,686.8 мянган төгрөгийн өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмж, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7а дахь заалтын дагуу багш Б.Сорцэцэгт 3,211.2 мянган төгрөг, багш Д.Дуламсүрэнд 3,211.2 мянган төгрөг, нийгмийн ажилтан Н.Пунсалдуламд 3237.6 мянган төгрөг бүгд 9,660.0 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсан 2 албан хаагчид 282.0 мянган төгрөгийн, жирэмсэн амаржсан 5 эхэд 10,524.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

Захирал Х.Тамжидад аймгийн Засаг даргын 2018 оны Б/46, А/574 дугаар захирамжаар 01-06, 08-12 сард үндсэн цалингийн 20 хувиар 1,305.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, аймгийн Засаг даргын 2018 оны А/583, А/696, А/712 дугаар захирамжаар 2, 3, 4-р улиралд үндсэн цалингийн 20-30 хувиар тооцож 535.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин, Хангал сумын Засаг даргын 2018 оны 04 сарын 18-ны өдрийн Б/12 дугаар, 2018 оны 12 сарын 14-ний өдрийн Б/28 дугаар захирамжуудыг үндэслэн 2017, 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн гэрээгээ хангалттай биелүүлсэнд үндсэн цалингийн 40 хувиар буюу 570.9 мянган төгрөгийн шагналт цалин тус тус урамшуулсан.

Хангал сумын суурь боловсролын сургуулийн захирлын Б/07, Б/24, Б/41, Б/53 дугаар тушаалуудыг үндэслэн 1-р улиралд 30 албан хаагчид 20-44 хувиар тооцож 5,142.9 мянган төгрөг, 2-р улиралд 32 албан хаагчид 15-44 хувиар тооцож 5,214.4 мянган төгрөг, 3-р улиралд 32 албан хаагчид 8-30 хувиар тооцож 2,924.1 мянган төгрөг, 4-р улиралд 33 албан хаагчид 10-42 хувиар тооцож 5,834.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

Суурь боловсролын сургуулийн захирлын 2018 оны 09 сарын 25-ны өдрийн Б/42 дугаар тушаалыг үндэслэн сургалтын менежер Ш.Алтанчимэгт 9-12 сард үндсэн цалингийн 25 хувиар тооцож 674.2 мянган төгрөгийн, байгууллагын даргын шийдвэрийг (өмнөх оны) үндэслэн нярав П.Наранцэцэгт 01-06, 08-12 сард үндсэн цалингийн 25 хувиар тооцож 1257.3 мянган төгрөгийн **ур чадварын нэмэгдэл**,

Мөн 2018 оны 02 сарын 09-ны Б/06 дугаар тушаалыг үндэслэн Төвийн болон баруун бүсийн “Цанын тэмцээн”-д өөрөө болон бэлтгэсэн сурагчид нь алт, мөнгө, хурал медаль хүртсэнд багш С.Алтангэрэлд үндсэн цалингийн 20 хувиар 115.6 мянган төгрөг, аймгийн математикийн “Бага сорил” олимпиадад хүрэл медаль хүртсэн багш

Ю.Үүрийнтуяад үндсэн цалингийн 15 хувиар 80.3 мянган төгрөг, *03 сарын 15-ны өдрийн Б/08 дугаар тушаалыг* үндэслэн Төв аймгийн Жаргалант суманд зохион байгуулагдсан өсвөр үеийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээнд сурагчид нь 2-р байр эзэлж мөнгөн медаль хүртсэнд багш С.Алтангэрэлд үндсэн цалингийн 20 хувиар 115.6 мянган төгрөг, “Уяачид дуулж байна” улсын анхдугаар уралдаанд аймаг, сумаа төлөөлөн оролцож шилдгээр шалгаран гала тоглолтонд оролцсон слесарь А.Батболдод үндсэн цалингийн 20 хувиар 81.0 мянган төгрөг, *04 сарын 17-ны Б/14 дугаар тушаалыг* үндэслэн нэгдүгээр ангийн сурагчдын “Эрдмийн баяр” болж байгааг тохиолдуулан сурагчдаа амжилттай сургасан багш Б.Жаргалсайханд үндсэн цалингийн 25 хувиар 152.1 мянган төгрөг, *05 сарын 21-ний Б/21 дугаар тушаалыг* үндэслэн аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн “Мини волейбол”-ын болон 15-16 насны тэмцээнд бэлтгэсэн сурагчид нь амжилттай оролцож 1-р байр эзэлж алтан медаль хүртсэнд багш С.Алтангэрэлд үндсэн цалингийн 15 хувиар 86.7 мянган төгрөг, аймгийн химийн төрөлжсөн цахим болон Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит химийн олимпиадад бэлтгэсэн сурагчид нь 2,3-р байр эзэлж мөнгө, хүрэл медаль хүртсэнд багш Г.Жаргалд үндсэн цалингийн 15 хувиар 91.3 мянган төгрөг, Улаанбаатар хотын “Номч” дунд сургуулийн нэрэмжит эссэ бичлэгийн уралдаанд бэлтгэсэн сурагчид нь 1,3-р байр эзэлж алт, хүрэл медаль хүртсэнд багш Д.Цэцэгтогтоход үндсэн цалингийн 15 хувиар 80.9 мянган төгрөг, *10 сарын 18-ны Б/46 дугаар тушаалыг* үндэслэн Булган суманд зохион байгуулагдсан орос хэлний масс олимпиадад анги хамт олон нь тэргүүн байр эзэлсэнд багш Г.Жаргалд үндсэн цалингийн 25 хувиар 144.5 мянган төгрөг, *11 сарын 22-ны Б/48, Б/49 дугаар тушаалыг* үндэслэн Булган суманд зохион байгуулагдсан “Уулзвар бүсийн математикийн олимпиад-21”- д бэлтгэсэн шавь нь амжилттай оролцож гутгаар байр эзэлсэнд үндсэн цалингийн 15 хувиар тооцож багш Д.Дуламсүрэнд 87.4 мянган төгрөг, багш Б.Жаргалсайханд 102.6 мянган төгрөг **бүгд 1,137.9 мянган төгрөгөөр** шагнаж урамшуулсан байна.

8.2 Өглөг, авлагын талаар:

2018 онд хоол хүнсний 21.6 мянган төгрөгийн өглөгтэй, ЭМНДШимтгэлийн 126.1 мянган төгрөгийн авлагатай тайлан баланс гаргасан байна.

8.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	293,919,034	1,170,569,383.59		1,464,488,417.59
2	Авто тээврийн хэрэгсэл	16,255,900			16,255,900
3	Машин тоног төхөөрөмж	40,370,953	4,979,500	522,000	44,828,453
4	Тавилга, эд хогшил	106,654,082.66	4,093,400	787,822.50	109,959,660.16
5	Номын фонд	9,148,273.86	106,900	3,463,394.36	5,791,779.50
6	Бусад үндсэн хөрөнгө	5,716,909.40			5,716,909.40
7	Программ хангамж /нярав/	250,000			250,000
8	Газар	0	16,638,000	4,773,216.86	

	Дүн	472,315,152.92	1,196,387,183.59	4,773,216.86	1,663,929,119.65
--	------------	-----------------------	-------------------------	---------------------	-------------------------

Тайлант онд төсвийн хөрөнгө Саммит компьютер технологи ХХК-иас 699.9 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 43 инчийн зурагт 3 ш, 389.9 мянган төгрөгөөр 32 инчийн зурагт 1 ш, 1499.9 мянган төгрөгөөр зөөврийн компьютер 1 ш, Орхон аймгийн зуу айл БМДэлгүүрээс 350.0 мянган төгрөгөөр 2 ш вакум насос, иргэн Ё.Наранцэцэгээс 660.0 мянган төгрөгөөр 2 ш вакум насос, 106.9 мянган төгрөгөөр ном худалдан авсан, бага ангийн багш Б.Жаргалсайхан 680.0 мянган төгрөгийн үнэтэй 41 инчийн зурагт хандивласан, БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд 1,249.5 мянган төгрөгийн 5 ш номын тавиур, бага ангийн STEM-ийн сургалтанд зориулж 448.4 мянган төгрөгийн 4 ш ширээ, 896.0 мянган төгрөгийн 16 ш сандал, 799.9 мянган төгрөгийн 43 инч зурагт үнэ төлбөргүйгээр өгч, сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 сарын 28-ны өдрийн 74 дугаар тогтоолоор он удаан жил ашиглагдсан, цаашид ашиглах боломжгүй болсон 3 нэрлийн 522.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7 нэр төрлийн 887.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 71 нэр төрлийн 3467.7 мянган төгрөгийн ном актлан, данс бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын тогтоолын дагуу эргэлтийн бус хөрөнгө болох газар, барилга байгууламжид дахин үнэлгээг хийсэн байна.

8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	1,011,584	801,666	817,584	995,666
2	Аж ахуй	1,685,660	1,571,900	843,200	2,414,360
3	Түлш шатах тослох	7,012,500	12,960,000	14,208,000	5,764,500
4	Барилгын засвар	1,785,050	5,328,040	2,662,890	4,450,200
5	Үдийн цай	1,325,880	6,839,800	7,213,090	952,590
6	Хүнс	2,727,276	13,218,890	13,186,551.50	2,759,614.50
7	Эм боох материал	59,900	111,400	86,800	84,500
8	Ном	2,570,850.56	368,362	1,712,352.22	1,226,860.34
9	Бусад хангамж	911,100	3,080,500	3,241,598	750,002
10	Бусад хангамж /эд хогшил/	31,269,498.87	5,566,900	759,745.38	36,076,653.49
11	Мал	7,060,000	5,455,000	4,815,000	7,700,000
	Дүн	57,419,299.43	55,302,458	49,546,811.10	63,174,946.33

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 49,461.0 мянган төгрөгийн бараа материал, БСУГазраас 18.1 мянган төгрөгийн үнэтэй багшийн журнал 9 ширхэг, анги удирдсан багшийн дэвтэр 6 ширхэг, БСШУСЯамнаас 368.4 мянган төгрөгийн үнэтэй 1-6-р ангийн сурах бичиг үнэ төлбөргүйгээр өгч, төлийн орлогоор 825.0 мянган төгрөг, нас дэвшилтээр 3770.0 мянган төгрөгийн мал нэмэгдэж, сургуулийн захирлын тушаалаар 910.0 мянган төгрөгийн мал зарлагдаж, зүй бус хорогдлоор 11 толгой буюу 415.0 мянган төгрөгийн мал зарлагдаж, байгууллагын үйл ажиллагаанд 43,237.8 мянган төгрөгийг зарцуулж, сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 сарын 28-ны өдрийн 74 дугаар тогтоолоор цаашид ашиглах боломжгүй болсон 20.0 мянган төгрөгийн уртасгагч, 3 нэрлийн 10.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3 нэр төрлийн 23.7 мянган төгрөгийн засварын материал, 98 нэр төрлийн 1,561.0 мянган төгрөгийн ном, 17

нэр төрлийн 759.7 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг актлан, данс бүртгэлээс хассан байна.

ЕС. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

- ✓ Санхүүгийн тайлан, мэдээг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагаар хянуулан баталгаажуулсан.
- ✓ Шинээр болон хандив, тусламжаар ирсэн хөрөнгийг тухай бүрд нь орлогод авч, данс бүртгэлд тусгасан.
- ✓ Анхан шатны баримт, баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт сайн, санхүү, аж ахуйн баримт материал эмх цэгцтэй үдэгдэж архивлагдсан.
- ✓ Хүнсний агуулахын бүртгэл, Дотуур байрны сурачдын ирцийн бүртгэлийг өдөр тутам, цэвэр нямбай маш сайн хөтөлсөн.
- ✓ Эд хариуцагч бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийгдсэн.

АРАВ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Албан томилотын үнэмлэхэд ирсэн, буцсан огноогүй байхад томилолтын зардлыг бодож олгосон,
2. Ур чадварын нэмэгдлийг улирал бүрийн ажил дүгнэсэн үнэлгээгүйгээр олгосон.
3. Бэлэн мөнгийг няраваар дамжуулан олгодоггүй, уралдаан тэмцээн, арга хэмжээний зардлыг хариуцсан албан хаагчид бэлнээр олгосон ба түүний зарцуулалтын баримтад анхан шатны баримт байхгүй, зөвхөн тавьж олгосон зарцуулалтын баримттай,
4. Түлээ хөрөөдсөн шатахууныг няравын тайланд тусгагдаагүй, бараа материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, бараа материалд тооцоо бодсон акт үйлдээгүй, туслах аж ахуйн тайлан, тооцоо үдэж архивлагдаагүй.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 1 актаар 120.5 мянган төгрөгийн төлбөр тогтоож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар байгууллагын удирдлага, нийгмийн ажилтан, нягтлан бодогч, нярав нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Нярав П.Наранцэцэгийг байлцуулан тус сургуулийн 2019 оны 06 сарын 17-ны өдрөөр тасалбар болгосон хүнсний тайлангийн үлдэгдэлд хийсэн биет тооллогоор байвал зохих хүнсний үлдэгдэл бүрэн, агуулах эмх цэгцтэй, бүртгэлийг өдөр тутам хөтөлж, агуулахын үлдэгдэлийг нягтлан бодогч шалгаж баталгаажуулсан байв.

ДҮГНЭЛТ

Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны баримт, баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт сайн байна.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, биелэлтийг тооцож, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

